



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/243

Хэрлэн сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай  
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 185 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/143 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрийн хөнөөлт мэрэгч их хэмжээгээр тархсан 9 сумын 38,3 мянган га бэлчээрт микробиологийн аргаар тэмцэх хаврын ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 30 хоног, “Энгийн механик, биологийн” аргаар мэрэгч амьтантай тэмцэх намрын ажлыг 10 дугаар сарын 01-ээс эхлэн 30 хоногийн хугацаанд тус тус зохион байгуулсугай.

2.Сумдын бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай “Микробиологийн аргаар” болон “Энгийн механик, биологийн” аргаар тэмцэх талбайн хэмжээг 1 хавсралтаар баталсугай.

3.Мэрэгч амьтантай тэмцэх ажилд иргэд малчид, малчдын бүлэг хоршоо, сумын мэргэжлийн ангийг хамруулж тэднийг мэрэгчтэй тэмцэх ажлын гарын авлага шаардлагатай техник хэрэгслээр хангаж, сургалт явуулах бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээг авч, хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Сумын Засаг дарга нартай мэрэгчтэй тэмцэх ажлыг гэрээ байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Энх-Амгалан)-т тус тус даалгасугай.

5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн нийтийг хамарсан ажилд орон нутгийн ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангаж ажиллахыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар (Э.Хонгорзул)-д даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын гүйцэтгэлийн үр дүнг холбогдох байгууллагад мэдээлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Энх-Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
дугаар сарын 20-ны өдрийн  
... дугаар захирамжийн хавсралт

### ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

№	Сумын нэр	Тэмцэх шаардлагатай талбайн хэмжээ /мян.га /	Хавар тэмцэх талбай /мян,га/	Микробиологийн бэлдмэл /тн/	Намар тэмцэх талбай /мян,га/
1	Баянхутаг	123334	4,0	6,0	
2	Галшар	407000	4,5	7,0	
3	Баян-Овоо	132557			5,0
4	Батноров	380000			5,0
5	Норовлин	120000			5,0
6	Жаргалтхаан	170072			5,0
7	Цэнхэрмандал	20000	2,5	4,0	
8	Мөрөн	50000	1,1	1,5	5,0
9	Хэрлэн	70000	1,2	1,5	
	Дүн	147296,3	13,3	20,0	25,0